

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал	8
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	16
2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	16
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	26
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	26
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	28
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ ХАМГААЛАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	32
БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	36
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	38
БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 0000116747 дугаартай, 2.8 га газрын булангийн цэгүүд ..3	
Хүснэгт 2. Ажилчдын орон тоо	9
Хүснэгт 3. Цул бетон үйлдвэрлэх хэмжээ сар, өдөр, жилээр	10
Хүснэгт 4. 1 төмөр бетон үйлдвэрлэх хэмжээ сар, өдөр, жилээр	10
Хүснэгт 5. Эн Си Ди Прекон үйлдвэрийн бетон, төмөр бетон хийц эдлэл үйлдвэрлэх ажлын тойм төлөвлөгөө	11
Хүснэгт 6. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	26
Хүснэгт 7. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал ..28	
Хүснэгт 8. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ	29
Хүснэгт 9. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	32
Хүснэгт 10. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	33
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	34
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	36
Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	38
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	39
Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	40

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг	5
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг	6
Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг	7
Зураг 4. “Прекаст” үйлдвэрийн фото зураг	8
Зураг 5. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	9
Зураг 6. Дулаан боловсруулалтын график	13
Зураг 7. Хучилтын нүхтэй хавтанг хураасан байдал	14
Зураг 8. Хучилтын нүхтэй хавтанг зориулалтын хавчаараар хавчсан байдал	14
Зураг 9. Химийн нэмэлт ашигладаг бетон төмөр бетон эдлэлийн технологийн бүдүүвч ...	15
Зураг 10. Төслийн талбайн районы д.т.д өндөршлийн зураг (метр)	17
Зураг 11. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)	18
Зураг 12. Улаанбаатар хотын уур амьсгалын горим	19
Зураг 13. Салхины хурдны жилийн явц	20
Зураг 14. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018)	20
Зураг 15. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт	21
Зураг 16. Төслийн талбайн районы гадаргын усны зураг	23

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Прекаст үйлдвэр”-ийн төсөл

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Төслийн нэр:

- “Прекаст үйлдвэр”-ийн төсөл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Эн Си Ди прекон” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 9011820687

- Регистрийн дугаар: 6607209

Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас

- Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Их Монгол улс, ривер гарден, 312, 602 тоот

- Утас: 77001919

Төслийн товч танилцуулга, хүчин чадал

- “Прекаст үйлдвэр” нь жилд 4320 м³ хучилтын нүхтэй хавтан, 3600 м³ ханын хавтгайлж, 1200 м³ зоорины ханын гулдмай, 360 м³ шат, 720 м³ багана суурь, 1680 м³ багана дам нуруу үйлдвэрлэх хүчин чадалтай.

Төслийн зорилго

- “Эн Си Ди прекон” ХХК нь барилгын хийц, эдлэл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2020 онд байгуулагдсан. Тус компани нь дотоодын төдийгүй, олон улсын стандарт нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилготой ажиллаж байна.

Төслийн байриил:

Эн Си Ди прекон” ХХК-ийн “Прекаст үйлдвэр”-ийн төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд байрлана.

> Талбайн хэмжээ: 28050.0 м²

> Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: Ы-48-10


Газарзүйн солбицол:

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 0000116747 дугаартай, 2.8 га газрын булангийн цэгүүд


№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	42	50.7	47	53	33.6
2	106	42	50	47	53	39.3
3	106	42	51.6	47	53	39.5
4	106	42	51.7	47	53	38.6
5	106	42	52.7	47	53	38.7
6	106	42	53	47	53	37

7	106	43	0.4	47	53	37.7
---	-----	----	-----	----	----	------

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
8	106	43	0.7	47	53	36.1
9	106	43	3.9	47	53	36.3
10	106	43	4.4	47	53	36.3
11	106	43	4.6	47	53	34.9



Зураг 1. Засаг захиргааны зураг



Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг



Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

Төсөл хэрэгжүүлэгч: “Эн Си Ди прекон” ХХК

1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал

“Эн Си Ди прекон” ХХК нь барилгын хийц, эдлэл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2020 онд байгуулагдсан. Тус компани нь дотоодын төдийгүй, олон улсын стандартад нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилготой ажиллаж байна.


Прекаст үйлдвэрийн технологи үйл явц

- > Хэрэглэгчээс захиалга авах, шаардлага нөхцөлийг тодорхойлох;
- > Түүхий эд материалыг ханган нийлүүлэгчийг сонгох;
- > Шаардлагатай тохиолдолд бетон зуурмагийн орц найрлагыг туршилтаар тогтоох;
- > Түүхий эд материалыг хүлээж авах;
- > Түүхий эд материалыг хадгалах, хуваарьт шинжилгээнд хамруулах;
- > Бетон зуурмагийг үйлдвэрлэх;
- > Бетон зуурмагийг зөөвөрлөх;
- > Эдлэлийг үйлдвэрлэх;
- > Хэрэглэгчид нийлүүлэх.



Зураг 4. “Прекаст” үйлдвэрийн фото зураг

Прекаст үйлдвэрийн бүтэц зохион байгуулалт ажиллах хүч



Зураг 5. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

Хүснэгт 2. Ажилчдын орон тоо

Алба, хэлтэс	Албан тушаал	Орон тоо
Удирдлага	Гүйцэтгэх захирал	1
	Ерөнхий менежер	1
	ХЭМАН-ын ажилтан	1
	Ахлах нягтлан бодогч	1
	Хүний нөөцийн менежер	1
	Нярав	1
	Ахлах менежер	1
	Үйлдвэрлэлийн инженер	1
Бетон зуурмаг хийц эдлэлийн цех	Бэлэн бүтээгдэхүүний цехийн мастер	1
	Тоног төхөөрөмжийн оператор	3
	Бетон зуурмагийн узелийн оператор	1
	Машин механизмын оператор	1
	Бетон арматурчин	8
	Кранист	2
	Туслах ажилтан	1
	Арматурын цехийн мастер	1
Арматурын цех	Бетон арматурчин	7
	Кранист	2
	Технологич инженер	1
Лаборатори	Лаборант	1
	Механикийн инженер	1
Механикийн хэлтэс	Сантехникийн инженер	1
	Цахилгааны инженер	1
	Гагнуурчин	2
	Сантехникч	2
	Цахилгаанчин	2
	Ахлах инженер	1
	Механикийн инженер	1

Алба, хэлтэс	Албан тушаал	Орон тоо
	Нийт	47

Төслийн хүчин чадал

Тус “Прекаст үйлдвэр” нь 5 жилийн ажлын төлөвлөгөөгөөр цул бетон 1-2 дахь жил өдөрт 23 м³, сард 460 м³, жилд 5520 м³, 3 дахь жил өдөрт 28 м³, сард 560 м³, жилд 6720 м³, 4-5 дахь жил өдөрт 46 м³, сард 920 м³, жилд 11040 м³ үйлдвэрлэнэ.

Төмөр бетон эдлэл 1-2 дахь жил өдөрт 26.5 м³, сард 530 м³, жилд 6360 м³, 3-5 дахь жил өдөрт 22 м³, сард 440 м³, 5280 м³ тус үйлдвэрлэнэ.

Хүснэгт 3. Цул бетон үйлдвэрлэх хэмжээ сар, өдөр, жилээр

Бетоны төрөл	хэмжих нэгж	1-2 дахь жил			3 дахь жил			4-5 дахь жил		
		Өдөр	Сар	Жил	Өдөр	Сар	Жил	Өдөр	Сар	Жил
Цул бетон	м ³	23	460	5520	28	560	6720	46	920	11040

Хүснэгт 4. 1 төмөр бетон үйлдвэрлэх хэмжээ сар, өдөр, жилээр

Бетоны төрөл	хэмжих нэгж	1-2 дахь жил			3-5 дахь жил		
		Өдөр	Сар	Жил	Өдөр	Сар	Жил
Төмөр бетон	м ³	26.5	530	6360	22	440	5280

Мөн тухайн үйлдвэр нь ойрын 5 жилийн төлөвлөгөөнд үйлдвэрийг өргөтгөн томруулахаар төлөвлөөгүй болно.

Товчилсон үгсийн тайлбар:

1. ХНХ - Хучилтын нүхтэй хавтан
2. ХХ - Ханын хавтгайлж
3. ЗХГ - Зоорийн ханын гулдмай
5. БС - Багана суурь
6. ДН - Дамнуруу

Хүснэгт 5. Эн Си Ди Прекоп үйлдвэрийн бетон, төмөр бетон хийц эдлэл үйлдвэрлэх ажлын тойм төлөвлөгөө

№	Эдлэлийн нэр	Бетоны төрөл	хэмжих нэгж	1-р жил			2-р жил			3-р жил			4-р жил			5-р жил		
				Өдөр	Сар	Жил	Өдөр	Сар	Жил	Өдөр	Сар	Жил	Өдөр	Сар	Жил	Өдөр	Сар	Жил
1	ХНХ	Багсармал бетон	м³	18	360	4320	18	360	4320	18	360	4320	36	720	8640	36	720	8640
2	ХХ	Төмөр бетон	м³	15	300	3600	15	300	3600	15	300	3600	15	300	3600	15	300	3600
3	ЗХГ	Цул бетон	м³	5	100	1200	5	100	1200	10	200	2400	10	200	2400	10	200	2400
4	Шат	Төмөр бетон	м³	1.5	30	360	1.5	30	360	-	-	-	-	-	-	-	-	-
5	БС	Төмөр бетон	м³	3	60	720	3	60	720	-	-	-	-	-	-	-	-	-
6	Багана, ДН	Төмөр бетон	м³	7	140	1680	7	140	1680	7	140	1680	7	140	1680	7	140	1680
7	Нийт		м³	49.5	990	11880	49.5	990	11880	50	1000	12000	68	1360	16320	68	1360	16320

Химийн нэмэлт ашигладаг бетон төмөр бетон эдлэлийн технологи

Бетон зуурмаг үйлдвэрлэх технологи үйл ажиллагаа

Технологийн үндсэн зарчим, бүтэц дараалал: Үйлдвэрлэлийн технологи нь түүхий эд материалыг хадгалж нөөцлөх, бетон хольц зуурах, зөөвөрлөх, үйлдвэрлэх гэсэн үндсэн дамжлагаас бүрдэнэ.

Түүхий эд, материалыг хадгалах, зөөвөрлөх: Дүүргэгч материалыг зориулалтын фракцаар нь ангилан хадгална. Том, жижиг дүүргэгч буюу ширхгээр нь ангилсан том дүүргэгчүүд хоорондоо холилдохоос сэргийлсэн байна. Дүүргэгч материалыг завсрын бункерээр дамжуулан туузан дамжуулагчаар зөөвөрлөж зарцуулалтын бункерт хийнэ.

Зөөвөрлөх, завсрын болон зарцуулалтын бункерт хийхдээ дүүргэгчийн төрөл ангиллыг холих, бохирдуулахыг хориглоно. Дүүргэгч материалын нөөц нь 7 хоногийн хэрэгцээнээс багагүй байна.

Цементийг ус, чийг орохооргүй зориулалтын силосонд хадгалах бөгөөд 100 тн багтаамжтай 2 силостой. Цементийг шнек төхөөрөмж ашиглан битүү байдлаар зөөвөрлөж зориулалтын бункерт хийнэ. 3 сараас дээш хугацаагаар хадгалсан цементийг шинжилгээний үр дүнд тулгуурлан хэрэглэнэ. Цементийн нөөц нь 7 хоногийн хэрэглээнээс багагүй байх ба үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тасалдахгүйгээр тооцно.

Усыг гүний худгийн шугамаас авч хэрэглэдэг.

Бетонд хэрэглэх нэмэлтийг МК8 6458:2014 стандартын дагуу хадгална. Хадгалалтын горим зөрчсөн нэмэлтийг хэрэглэхийг хориглоно. Химийн нэмэлтийн нөөц нь 3 сарын хэрэглээнээс багагүй байвал зохино.

Бетон зуурмагт хэрэглэх дүүргэгч, барьцалдуулагч материалыг жингээр, ус шингэн нэмэлтийг жингээр буюу эзлэхүүнээр хэмжинэ.

МК8 1185:1998 “Бетон зуурмаг. Техникийн шаардлага” стандартын 2.4-д заасны дагуу хэмжил зүйн албанаас тугнуурыг шалгаж тохируулан гэрчилгээ олгосон байх ёстой. Хэрэв заалтын алдаа зөвшөөрөгдөх хэмжээнээс их байвал яаралтай мэргэжлийн байгууллагаар тохируулан баталгаажуулна.

Бетон хольц зуурах, зөөвөрлөх: Тус үйлдвэр нь бүрэн автомат удирдлагатай, 2 голт албадмал ажиллагаатай чөлөөт уналтын зуурагчаар бетон зуурмагийг зуурдаг. Зуурагч тогоо нь нэг удаа 1.5 м³ хүртэлх бетон хольц зуурах багтаамжтай бөгөөд хуурай хольц /элс, дайрга, цемент/-ыг зуурагчид хийж сайтар хольсны дараа ус, нэмэлтийг хийж, жигд найрлагатай болтол нь үргэлжлүүлэн зуурна. Бэлэн болсон зуурмаг нь бөөгнөрсөн бүхэл хэсэггүй байх ба бетон хольц үелэхгүй, технологийн шинж чанар /конусан суулт, аргуун чанар/ орцын нормд заасны дагуу байна.

Зуурсан зуурмагийг тус бүр нь 1.5 м³ багтаамжтай 2 ширхэг тээвэрлэгч бункерээр хийц эдлэлийн цех рүү зөөвөрлөнө. Тээвэрлэгч бункерээс тараагч бункер лүү бетон зуурмагийг дамжуулснаар бетон төмөр бетон эдлэл үйлдвэрлэл явагдана. Зөөвөрлөлтийн явцад бетон хольцыг доргиож нягтруулах, зуурснаас хойш 30 минутаас дээш хугацаагаар саатаж зогсохыг хориглоно.

Бетон төмөр бетон эдлэл үйлдвэрлэх

Арматур бэлтгэх: Хүчитгэсэн болон энгийн арматурыг цехэд зориулалтын бэлтгэсэн талбайд байрлуулна. Арматурын бэлдэц бэлтгэхдээ ажлын зурагт заасны дагуу таслах, тор сараалж бэлтгэх, матах, боож бэлтгэх, шалгах гэсэн үндсэн дараалал, зарчмаар

гүйцэтгэнэ. Эдлэлд байрлах ган деталиуд болон өргөх сэнжийг ажлын зурагт заасны дагуу бэлтгэж гагнан арматурын бэлдцэд байрлуулна.

Хэв бэлтгэх: Хэвийг бетоны үлдэгдэлгүй гөлгөр гадаргуутай болтол маш сайн цэвэрлэж, зориулалтын эмульсэн суурьтай тосоор тосолно. Тосолсон гадаргууг арчих, бохирдуулахыг хориглоно. Хэвийг тослохдоо тусгай шүршигч эсвэл порлон ашиглан хэвтээ болон босоо чиглэлд 0.2 мм орчим зузаантай байхаар бүх гадаргууг бүрхүүлж жигд түрхэнэ. Хэвийн цэвэрлэгээ, тосолгоог шалгасны дараа хэвд арматурын бэлдцийг байрлуулна. Хэвийг угсарч бэлтгэн, хэвийн бэхлэгээг хийнэ. Хучилтын нүхтэй хавтангийн хэвийг сайтар цэвэрлэж, тохируулан зам дээр байрлуулна.

Бетон хольц цутгах нягтруулах: Хучилтын нүхтэй хавтангийн тараагчид зуурмагийг хийж хэвлэх машины хурдыг тохируулан шнекээр бетоныг шахаж гарган нягтруулах маягаар үйлдвэрлэл явагдана. Бусад бүтээц эдлэлийг үйлдвэрлэхдээ тараагч бункерээр бетон хольцыг тарааж, хэвд бэхлэгдсэн зориулалтын доргиурын тусламжтайгаар нягтруулна. Дараагаар нь эдлэлд өнгөлгөө хийнэ.

Эдлэлийг бэхжүүлэх: Бетон 28 хоногийн дараа бэхжилээ бүрэн авсан байх ёстой. Бетоны бэхжилийг хурдасгах зорилгоор уурын орчинд дараах байдлаар чийг дулааны боловсруулалт хийнэ. Хучилтын нүхтэй хавтанг цутгахаас өмнө замыг халаасан байна. Бусад эдлэлийн хэвийг хэвийн бэхлэгээ хигдсэний дараагаар халаасан байна. Зам дээр цутгасан төмөр бетон нүхтэй хавтанг тухай бүрд нь хучлагаар хучиж явна. 50°C-ийн температурт 12-16 цаг дулааны боловсруулалт хийнэ. Бусад эдлэлийг өнгөлгөө хийсний дараагаар зориулалтын хучлагаар хучиж 50°C-ийн температурт 12 цаг дулааны боловсруулалт хийнэ.

Троссыг сүвлэж, хүчитгэн бэлтгэх: Троссны тоог захиалгын дагуу сүвлэж, хамгаалалтын гинжийг хийж бэхэлнэ. Хяналт дор троссны хүчитгэлийн ажлыг явуулна.

- > Цехийн буюу ердийн барилт 1 цаг;
- > Температурыг өсгөх үе шат 2 цаг;
- > Өссөн температурт барилт хийн бэхжүүлэх үе шат 7 цаг;
- > Температурыг аажмаар бууруулах үе шат 2 цаг.



Зураг 6. Дулаан боловсруулалтын график


Бэхжилтийн дараагаар төслийн бат бэхийн 70 хувийг авсан байх шаардлагатай.

Хучилтын нүхтэй хавтанг хөрөөдөх: Хучилтын нүхтэй хавтан нь 1 зам дээр 118 метр хүртэл урттайгаар үйлдвэрлэгддэг бөгөөд төслийн бат бэхийн 70 хувийн бэхжилтийг авсны дараагаар үйлдвэрлэлийн инженерээс ирсэн даалгаврын дагуу хэмжээ тавина. Хэмжээсний дагуу бетоны хөрөөний оператор хучилтын нүхтэй хавтанг алдаагүй зүсвэрлэнэ.


Эдлэлийг шалгаж хүлээн авах, хаяглах, хадгалах, тээвэрлэх: Эдлэлийг шалгаж хүлээн авахдаа геометр хэмжээс болон ан цав хагарал, деталийн хөдөлгөөн, нүх сүв, овгор товгор зэргийг шалгах хуудасны дагуу хүлцэх алдаанд бариулан шалгаж хүлээн авна. Хүлээн авсан эдлэлийг ажлын зураг болон маркийн дагуу нүдэнд ил харагдахаар хаягжуулна. Мөн эдлэл дээр байгууллагын нэр, эдлэл үйлдвэрлэсэн огноо байрлана.

Эдлэлийн бат бэхийн үзүүлэлтийг нэг хэсгээс авсан бетон шоо болон шмидтын алхаар тодорхойлж хүлээн авна.


Эдлэлийг үйлдвэрийн бэлтгэсэн талбайд гүүрэн кранаар зориулалтын хавчаар, гинж, чалк ашиглан ивээсийг 1 тэнхлэгт байрлуулан стандартын дагуу хураана.



Зураг 7. Хучилтын нүхтэй хавтанг хураасан байдал




4.5 метр хүртэл урттай хавтанг жижиг хавчаараар зурагт заасны дагуу голлуулан хавчиж, тэгш өргөнө.



4.5 метрээс дээш урттай хавтанг зурагт заасны дагуу тэгш хэмтэй хавчиж, хазайлгалгүйгээр өргөнө.

Зураг 8. Хучилтын нүхтэй хавтанг зориулалтын хавчаараар хавчсан байдал

Тээвэрлэхдээ чанарын гэрчилгээний хавсралтад тусгасны дагуу зориулалтын авто машинаар даац хэтрүүлэлгүйгээр тээвэрлэнэ.



Зураг 9. Химийн нэмэлт ашигладаг бетон төмөр бетон эдлэлийн технологийн бүдүүвч

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Газрын гадаргуу: Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ.

Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим км үргэлжилсэн нуруу юм. Хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268 м өндөрт орших Цэцээ гүн юм. Тус ууланд 2000 метрээс дээш өргөгдсөн эртний тэгшрэлийн гадарга голлоно.

Хотын баруун хойд хэсэг нь 1831 м өндөр бүхий Толгойт, 1800 м өндөр бүхий Чингэлтэйн салбар уулсаар хүрээлэгдэнэ. Эдгээр уулс нь харьцангуй мөлгөр оройтой бөгөөд өвөр хажуу нь аажим намссаар Мааньт, Тасганы овоо, Нарангийн толгодорхог гадаргууд шилжиж үнэмлэхүй өндөр нь багасаж улмаар Туул голын хөндийн хэсэгт тулж очдог. Хотын баруун талд тектоник-дендуцийн гаралтай 1652 м үнэмлэхүй өндөртэй Сонгинохайрхан, Дарцагт, 1520 м өндөр Баян-Өндөр, Майхан толгой, Соёлд уул, Таширын нуруу, Улаан Ямаат, 1691 м өндөр Тахилт уулууд, зүүн талд 1527 м үнэмлэхүй өндөртэй Баянзүрх уул оршино.

Эдгээр уулс нь эгц хажуутай, хурц шовх оройтой, гарш хяруудыг үүсгэсэн байдаг. Дээрх өндөр уулсын муж болон уулс хоорондын хөндийн газрын гадаргын харьцангуй өндөршлийн зөрүү ихэвчлэн 400-500 м боловч заримдаа 700-920 м хүрдэг.


Туул голын хөндийн ай савын татмын үнэмлэхүй өндөр 1250-1345 м бөгөөд өргөний хэмжээ 1.2-4.0 км байдаг.

Толгойт, Баянхошуу, Баянцогт, Хойд Баян, Цагдуулт зэрэг нам уулсын мужийн үнэмлэхүй өндрийн хэмжээ 1515-1831 м ба тэдгээрийн хажуу ташлаг, энгэр, бэлийн налуу ихэвчлэн 15-20 хэм зарим тохиолдолд 30-35 хэм байдаг. Нэлээд өндөр өргөгдсөн уулсын мужийн хажуу ташлаг, энгэр, бэл, хормойг хөндлөн хэрчсэн олон тооны хуурай сайр, гуу жалга ховил түгээмэл ажиглагддаг.


Улаанбаатар хотын ихэнх барилга байгууламж нь Туул голын хөндийн ай сав болон Сэлбэ голын адаг хэсэг, Зүүн, Баруун Наран, Цагаан хуарангийн дэнжид тархжээ. Түүнчлэн, Туул голын хөндийн өмнөд жигүүрт Их, Бага тэнгэрийн аманд төр, засгийн тусгай объектууд тодорхой хамгаалалтын бүсэд оршдог.

Үүний зэрэгцээ Сэлбэ, Хөл, Бэлхийн голын хөндий, Туул голын Дээд Хар усан тохой, Могойн дэнж, Их Хуандай, Улиастай, Гачууртын голын адаг, Толгойтын голын Зүүн, Баруун салаа орчмоор хувийн орон сууцны зориулалттай бэсрэг цогцолбор, зуслангийн барилга байгууламж, гэр хорооллын объектууд нэлээд шигүү хэлбэрээр байрлаж байна (Эко Трейд ХХК, 2006).

Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1172.0 метрийн үнэмлэхүй өндөрт байрлаж, газрын гадаргын налуу буюу хэвгий 2.3 градус байна.



Зураг 10. Төслийн талбайн районы д.т.д өндөршлийн зураг (метр)




Зураг 11. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)

Улаанбаатар хотын уур амьсгалын горим: Улаанбаатар хот нь ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м өндөртэй Богд-Хан, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулын дунд Туул голын хөндийд байрладаг (Даваадорж. Д, 2020). Ерөнхийдөө өвөл нь удаан (цас их унана), зун нь богино (аагим халуун, хур тунадас ахиухан ордог ч үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хавар, намар хүчтэй шуургатай өдөр тохиолддог.

Бид Улаанбаатар хотын уур амьсгалыг тодорхойлохдоо далайн түвшнээс дээш 1300 м орших “Улаанбаатар” цаг уурын станцын 1969-2019 оны хоорондох олон жилийн агаарын температур, хур тунадас, салхины хурд гэсэн статистик үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Улаанбаатар станцын дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур -0.3°C байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд өвлийн улиралд -21°C , зуны улиралд $+19.3^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Агаарын температурын жилийн амплитуд дунджаар 23.7°C орчим байна.

Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын 3-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 9 дүгээр сарын 1-р 10 хоногт байна. Харин эцсийн хүйтрэлт дунджаар 6 дугаар сарын эхний 10 хоногт, хамгийн хожуу нь 6 дугаар сарын 2-р 10 хоногт тохиолдож, цочир хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 137 хоног байна.



Зураг 12. Улаанбаатар хотын уур амьсгалын горим


Хаврын саруудад орох тунадасны хэмжээ аажмаар ихэссээр 5 дугаар сард ихсэж хамгийн их хур тунадас 7 сард 75.1 мм, намар 9 дүгээр сараас хур тунадасны хэмжээ огцом багасаж, 11 дүгээр сараас өвлийн гормондоо шилжиж 1 сард хамгийн бага хур тунадас буюу дунджаар 2.4 мм унадаг байна. Хоногт хэт их бороо орох, өвөл цас их унаж, хавар огцом дулаарах нь гэнэтийн үер болоход хүргэж, хөрсний эвдрэлийг ихэсгэж, зам, харилцаа, барилга, байгууламжид хор хөнөөл учруулдаг. Анхны цас дунджаар 9 дүгээр сарын 3-р 10 хоногт унах бөгөөд 11 дүгээр сарын дундаас цасан бүрхүүл тогтож, 100 орчим хоног цасан бүрхүүлтэй байж 4 дүгээр сарын эхээр цас хайлж, 5 дугаар сарын эхэн гэхэд дуусна. Сүүлчийн цас хожуудаа 5 дугаар сарын дунд арав хоногт ажиглагддаг. Цасны зузаан 2-4 см байх ба зарим хунгарласан газраа хааяа 10-20 см хүрдэг. Цасны нягт $0.16-0.30 \text{ г/см}^3$ байдаг.

Жилийн нийлбэр хур тунадас дунджаар 248 мм унадаг үүнээс дулаан улирлын нийлбэр хур тунадас 220мм буюу 89%, харин хүйтний улирлын нийлбэр хур тунадас 28мм буюу 11% ноогдох бөгөөд хур тунадасны хэмжээгээр хээрийн бүсэд хамрагддаг

болохыг харуулж байна. Энэ бүс нутагт газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил өвөл, зун (1 ба 8 дугаар сард) хамгийн их, хавар намар (4 ба 10 дугаар сард) хамгийн бага болох ба жилийн дундаж утга нь 58,6% байна.


Салхины горим

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт салхины хурд олон жилийн дунджаар 2.4 м/с байдаг нь цаг агаар тогтуун бүс бүс нутаг юм.



Зураг 13. Салхины хурдны жилийн явц


Салхины хурдны жилийн явцаас харахад хамгийн их болон хамгийн бага утга нь тус бүр хоёр, хоёр тохиож байна. Үндсэн хамгийн их утга нь 5 сард дунджаар 3.3 м/с, хоёрдугаар их утга нь 9 сард дунджаар 2.6 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 1 сард дунджаар 1.2 м/с, хоёрдугаар бага утга нь 7 сард дунджаар 2.7 м/с тохиодог байна.



Зураг 14. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018)

Улаанбаатар станцын салхины зүгийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй жилд дунджаар баруун хойд зүгийн салхи 47.3 %-ийн

давтагдалтай зонхилох боловч зүүний салхи 15.9 % байгаа нь зэргэлдээх зовхисоосоо хавьгүй их давтагдалтай байна. Ялангуяа намар болон өвлийн улиралд энэ зүгийн салхи 13.0-14.3 % болж зонхилох зүг болдог. Энэ зүгийн салхины давтагдал хаврын сүүл сард нэлээд буурах боловч зуны саруудад ахин нэмэгддэг (НЗДТГ, 2018).



Зураг 15. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт


1969-2019 оны олон жилийн явцаас харахад жилийн агаарын дундаж температур ойролцоогоор 2.5°C-аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор тасралтгүй нэмэгдсээр буй нь Зураг 13-т харагдаж байна.

Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 1969 онд -2.58°C удаах хүйтэн жил -2.0°C байсан бол хамгийн дулаан жил 2007 онд 1.95°C хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтийн хандлагаас үзвэл өссөн болон буурсан тодорхой хандлага илрээгүй бөгөөд хур тунадасны хэмжээ 166,2-395,6 мм-ийн хооронд хэлбэлзсэн ба 1966-1981, 1994-2007 онд буурч 2007 оноос эхлэн өсөх хандлагатайгаар өөрчлөгдсөн байна.

Ус зүй: Төслийн талбай байрлах бүс нутаг нь Хойд мөсөн далайн ай сав, Туул голын сав газарт багтана.

Туул гол нь 6 дугаар эрэмбийн гол. Хан Хэнтий нурууны Бага Хэнтий сарьдгийн өврийн салбар уулсаас эх авах Номин гол, Шороотын даваа (1918 м)-ны өвөр, Шар булгийн сарьдаг (2542 м)-ийн салбар уулсаас эх авах Шороотын давааны өврийн голын бэлчрээс Туул хэмээн нэрлэгдэнэ. Голын ус хурах талбай 48868.4 км², урт нь 871 км, хэвгий 0.0021. Голдрилын дундаж өндөр 1160 м, ус хагалбарын шугамын урт 2055.6 км, түүний дундаж өндөр 1719.0 м, голын сүлжээний нягт бага 0.16 км/км², ус хураах талбайн дундаж өндөр 1300.0 м, хөндийн гүн дунджаар 559.0 м, ус хураах талбайн дундаж өргөн 56.1 км, сав газрын суналын зэрэг хамгийн их 16.5, ус хагалбарын шугамын тахиршлын зэрэг 2.6, хажуугийн хэрчигдэл бага 0,58, Хортгор-Страхлерийн хуулиар голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.2, 3.05, 5.572 тус тус байна. Энэ голын савд 1 дүгээр эрэмбийн сайр-горхи 1226, тэдгээрийн дундаж урт 2.3 км, ус хурах дундаж талбай 6.3 км², 2 дугаар эрэмбийн горхи 320, 3 дугаар эрэмбийн гол 64, 4 дүгээр эрэмбийн гол 14, 5 дугаар эрэмбийн гол 4 байна. Хэнтий нурууны салбар уулсаас эх авах Галттай, Хийдийн гол, Хаг, Хонгор, Зүүн ба Баруун Баян, Заан, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол, горхи Туул голд цутгана.

Төслийн талбайн урд зүгт ойролцоогоор 4.7 км зайд Туул гол урсаж байна. Төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй байна.



Зураг 16. Төслийн талбайн районы гадаргын усны зураг

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих газар нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн баруун хэсгийн 39-р тойргийн (Үндэсний атлас, 2009) нутгийг хамран байрлах бөгөөд хотжилт, гэр хорооллын нөлөөгөөр Хот суурины эвдэрсэн хөрс болон өөрчлөгдсөн байна (“Монгол орны хөрсний дижитал зураглал, хөрсний шинэчилсэн ангилал” сэдэвт ажлын тайлан, 2014). Дамбадаржаа орчмын Билгэхийн голын хөндий хэсгээр аллювийн ширэгт бараан хөрс болон аллювийн сайргархаг хөрсүүд бүрдэл байдлаар тархдаг байсан ба сүүлийн жилүүдийн хүн амын төвлөрөл, гэр хорооллын айл өрхүүд нэмэгдсэний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдрэл, доройтолд орж байгалийн унаган төрхөө бүрмөсөн алдсан тул хөрсний шинэчилсэн ангиллаар Хот суурины эвдэрсэн хөрсний ангилалд багтах болсон. Одоогийн байгаа хот суурины эвдэрсэн хөрс нь ялзмагт үе давхаргагүй болж зулгарсан, ургамалгүй, халцгай байх ба хөрсний дээжийг өнгөн үеийн 0-10 см гүнээс авсан.

Ургамлын нөмрөг: Төслийн талбайн ургамлын нөмрөг, байгалийн төрх бүрэн өөрчлөгдөж, хог ургамал бүхий бүлгэмдлээр солигдсон байсан ба өнгөн хөрс, газрын гадарга нь олон удаагийн эвдрэлд өртөж, сүүлд нь бүрэн хатуу хучилттай болгосон байна.

Төслийн талбайн ургамлын нөмрөг, байгалийн төрх бүрэн өөрчлөгдөж, хог ургамал бүхий бүлгэмдлээр солигдсон. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг авч үзвэл *СкелороШит анзШит* ^, *Скелоро&ит аситтаЫт ФШЛ*, *СкелороШит аlЪит* ^, *СкелороШит d1аисит* ^, *Аlnplex мЫnса* ^, *Ахунз рго^lгала* ^, *Ахунз атаганlкоШе\$* ^, *8аи\$\$игеа атага* ^С, *Сонзрегтит топдоксит Щт*, *Сонзрегтит ^ескнаЫт 8lерк*, *Агкчпта ^ndШа №НШ*, *А2lewlma тасгосеркала ^ас^ует*, *PolenШла анзenna* ^, *PolenШла туШ/Ша* ^, *игкса саппаЫна* ^ зэрэг хог ургамал давамгайлан ургасан байна. 10 м² талбайд дунджаар 8-21 зүйл ургамал тохиолдож, хүчтэй доройтсон.

Ан амьтан: Нийслэлийн ногоон бүс, түүний орчмын уулсаар экологийн олон янзын орчинд амьдардаг 17 зүйлийн хөхтөн амьтан, 82 зүйл шувуу бүртгэгджээ. Амьтны хувьд бүтээн байгуулалт, хүн амын нягтралаас үүдэн зүйл болон тоо толгой жилээс жилд цөөрч байгаа. Нийслэл хот орчмын шувуудыг тоо толгойн байдлаар авч үзвэл элбэг буюу олон тоогоор байнга тааралддаг 8 зүйл, ердийн буюу түгээмэл тааралддаг 31 зүйл, тоо толгой элбэг бус ховор 21 зүйл, цөөн тоогоор буюу нэн ховор 22 зүйл шувуу байдаг юм байна. (Нийслэлийн байгаль орчны төлөв байдал, 2011, хуудас 108-112). Дүүрэг тус бүрээр нь зэрлэг амьтан болон шувуудын нарийвчилсан судалгаа одоогоор байхгүй байна.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Монгол Улсын Их Хурлын 18 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 100 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй анхны хуралдааныг 1992 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хийжээ. Анхны хурлаас нийслэлийн Сонгинохайрхан дүүргийг 1992 оны 10 сарын 1-ний өдөр байгуулах тогтоол гарсан байна. Тус дүүрэг нь анх байгуулах тогтоол гарсан байна. Тус дүүрэг нь анх байгуулагдахдаа Сонгино нэртэй байв. Улмаар 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот “Дүүргийн нэрийг өөрчлөх тухай” тогтоолоор Сонгинохайрхан дүүрэг болгон өөрчилжээ.

Уг нэрийг нийслэл хотын баруун талд орших Сонгино хайрхан уулын нэрээр нэрлэсэн юм. Энэхүү уулын оргил нь далайн түвшнээс 1663 метр өндөр.

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтөөр ийнхүү Нийслэлийн Октябрь район буюу одоогийн Баянгол дүүргээс өрх тусгаарлан байгуулагджээ.

Сонгинохайрхан дүүрэг 43-н хороотой 341 орчим мянган хүн амтай нийслэлийн хамгийн том газар нутагтай дүүрэг юм.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

